



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

СОЁМБОМ ЭДЭЭ

№48 /262/ 2022.03.11

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

“НҮҮДЭЛ СУУДАЛ-ХОТЖИЛТ БА ЦЭРГИЙН СТРАТЕГИ” НОМЫН НЭЭЛТ БОЛЛОО



Оксфордын их сургуулийн хэвлэлийн газраас эрхлэн гаргасан Австралийн цэргийн стратегич Дэвид Киллүллэний бүтээл “Нүүдэл суудал-Хотжилт ба Цэргийн стратеги” номыг хошууч генерал, профессор Я.Чойжамц, Ч.Ариунбат нар орчуулан уншигчдын хүртээл болголоо. Номын нээлтэд БХЯ, ЗХЖШ-ын удирдлага, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, судлаач, дипломатч Р.Болд, нийтлэлч Баабар нарын хүндэт зочид төлөөлөгчид оролцлоо.

Энэхүү бүтээл нь өнөөдрийн дэлхий ертөнцийн өөрчлөлт, иргэдийн хот дагасан төвлөрөл, түүнийг дагасан асуудлын стратеги, шийдэлд шинэлэг байдлаар хандах хэрэгцээг харуулахыг зорьжээ. Толилуулан буй энэхүү бүтээл нь ирээдүйн мөргөлдөөн, хотуудын тухай, хүн ам зүй, хотжилт, далайн эрэг орчмын суурьшил, холбоо харилцаа зэрэг олон сэдвийн тухай өгүүлжээ.

Тус номонд өгүүлснээр хотууд нь ирээдүйн зөрчилдөөний дүн шинжилгээ хийх нэн чухал

объект бөгөөд ирээдүйд тогтвортой байдал биш харин уян хатан, дасан зохицох чадвар гол зорилт байх болно гэжээ. Өдрөөс өдөрт дэлхийн хүн ам өсөж, мега хотууд олноор

бий болж байгаа нь бидэнд ямар аюулыг дуудна вэ? энэ асуултыг хариултыг тус номоос уншигч та бүхэн олоорой.

ЦЭРГИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧ, ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР БЭЛТГЭХ СУРГАЛТ ЯВАГДАЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

Зэвсэгт хүчинд нэн шаардлагатай байгаа чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Батлан хамгаалахын сайдын санаачилсан “Хүний хөгжлийн менежер”, “Цэргийн сэтгэл зүйч”-ийг бэлтгэх мэргэшүүлэх сургалт амжилттай явагдаж өндөрлөлөө.

Төгсөлтийн арга хэмжээнд ЗХЖШ-ын ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзвэг, ҮБХИС-ын захирал, бригадын генерал П.Жаргалан, БХЯ-ны ТЗУГ-ын хэлтсийн дарга Д.Содномдаржаа, ҮБХИС-ийн хүндэт профессор А.Гэлэгжамц болон албаны бусад хүмүүс оролцлоо.

Өнгөрөгч оны 12 дугаар сарын 3-наас энэ сарын 10-н хүртэлх хугацаанд явагдсан

тус сургалт нь ҮБХИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийг түшиглэн явагдсан бөгөөд 504 цагийн практик чадвар, дадал эзэмшүүлэх хичээл оржээ.

“Цэргийн сэтгэл зүйч” бэлтгэх мэргэшүүлэх сургалтад иргэний боловсролын их, дээд сургуулийг сэтгэл судлал, сэтгэл зүйч мэргэжлээр төгссөн цаашид цэргийн сэтгэлзүйн чиглэлээр ажиллах хүсэл сонирхолтой суралцагсдын хамруулсан бол “Хүний хөгжлийн менежер”-ийн сургалтад Зэвсэгт хүчинд офицер, ахлагчийн албан тушаалд ажилладаг, бакалаврын зэрэгтэй, дипломын голч дүн 2,7-оос доошгүй, мөн цаашид энэ чиглэлээр ажиллах хүсэл, сонирхолтой залуусыг тус тус шалгаруулан тус сургалтад хамруулсан юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

Өдөр	Шөнө
-5	-17

ӨМНӨД СУДАН

Өдөр	Шөнө
42	28

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,886.00	2,895.0
EUR	3,195.0	3,205.0
CNY	457.00	458.00
RUB	27.00	29.00
JPY	24.95	25.10
KRW	2.39	2.41

ЗУРХАЙ



2022.03.11 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 9/

ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин өчүүхэн ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.14-17.51

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Суудал: Огторгуй

Энэ өдөр хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдвэр үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, сүм дуганыг сэргээх, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар ухах, худаг гаргах, гөлөг тэжээх, уул овоо тахидах муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



МЕНИНГИТ ӨВЧИН

- МЕНИНГИТ нь менингококкоор үүсгэгдэх маш богино хугацаанд хүчдэг эрсдэлтэй халдварт өвчин.
- Агаар дуслын замаар болон бохир гар, хүнсний зүйлсээр дамжин халдварладаг.
- Бала насны хүүхдэд өртөх эрсдэл илүү өндөр байдаг.

ИЛРЭХ ШИНЭ ТЭМДЭГ	СРЬЛЧИЛАН СЭРҮҮЛЭХ АРТЗЭД
ГЭСЭТ ӨНӨР ХАЛДВАХ	ХАМЬР КОЛОН ГЭРЭГ БЭЭН ГҮХЭГ ҮРЭВЭЙГ КОРТЭЛЭЙ ЗИЙНИ ЗАРЫН ДАСАЛТЫН ЭМНЭЛТ
БӨӨНӨЙ	ГЭВЭС БЭЭНЭЭ ДАРИН ГЭВЭС ӨНӨЛӨӨНӨӨСӨН ГЭВЭС СЭРҮЭГ САРЫНХАЙН ХӨСӨЛӨЙ АН ГЭВЭС КОЛОНГОТ ГЭТЭЙ ЗАХИ
СӨЛӨЧ	МЕНАГОКОКТОК ХАЛДВАРЫН СЭРҮЭГ БАЙГУУЛГА
СӨЛӨХ	ГЭВЭС БЭЭНЭЭ ДАРИН ГЭВЭС ӨНӨЛӨӨНӨӨСӨН ГЭВЭС СЭРҮЭГ САРЫНХАЙН ХӨСӨЛӨЙ АН ГЭВЭС КОЛОНГОТ ГЭТЭЙ ЗАХИ
ХСРЛЭГЭЛЭГ, СЭВЧИМЭЭ ЗЭРГЭТ	ГЭВЭС БЭЭНЭЭ ДАРИН ГЭВЭС ӨНӨЛӨӨНӨӨСӨН ГЭВЭС СЭРҮЭГ САРЫНХАЙН ХӨСӨЛӨЙ АН ГЭВЭС КОЛОНГОТ ГЭТЭЙ ЗАХИ
ЦЭВЭРЛЭГ	ГЭВЭС БЭЭНЭЭ ДАРИН ГЭВЭС ӨНӨЛӨӨНӨӨСӨН ГЭВЭС СЭРҮЭГ САРЫНХАЙН ХӨСӨЛӨЙ АН ГЭВЭС КОЛОНГОТ ГЭТЭЙ ЗАХИ
ТЭВЭРЛЭГ	ГЭВЭС БЭЭНЭЭ ДАРИН ГЭВЭС ӨНӨЛӨӨНӨӨСӨН ГЭВЭС СЭРҮЭГ САРЫНХАЙН ХӨСӨЛӨЙ АН ГЭВЭС КОЛОНГОТ ГЭТЭЙ ЗАХИ
ХӨСӨЛӨГ	ГЭВЭС БЭЭНЭЭ ДАРИН ГЭВЭС ӨНӨЛӨӨНӨӨСӨН ГЭВЭС СЭРҮЭГ САРЫНХАЙН ХӨСӨЛӨЙ АН ГЭВЭС КОЛОНГОТ ГЭТЭЙ ЗАХИ
ХӨСӨЛӨГ	ГЭВЭС БЭЭНЭЭ ДАРИН ГЭВЭС ӨНӨЛӨӨНӨӨСӨН ГЭВЭС СЭРҮЭГ САРЫНХАЙН ХӨСӨЛӨЙ АН ГЭВЭС КОЛОНГОТ ГЭТЭЙ ЗАХИ
ХӨСӨЛӨГ	ГЭВЭС БЭЭНЭЭ ДАРИН ГЭВЭС ӨНӨЛӨӨНӨӨСӨН ГЭВЭС СЭРҮЭГ САРЫНХАЙН ХӨСӨЛӨЙ АН ГЭВЭС КОЛОНГОТ ГЭТЭЙ ЗАХИ
ХӨСӨЛӨГ	ГЭВЭС БЭЭНЭЭ ДАРИН ГЭВЭС ӨНӨЛӨӨНӨӨСӨН ГЭВЭС СЭРҮЭГ САРЫНХАЙН ХӨСӨЛӨЙ АН ГЭВЭС КОЛОНГОТ ГЭТЭЙ ЗАХИ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,271,860 /69.8%	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,173,366 /66.8%	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,026,782 31,6% 107,441 /3,3%
---	--	---

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 8408 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 83	ЭДГЭРСЭН 8205
------------------------------	---------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 453,639,251

Эдгэрсэн

Нийт: 387,593,049

Нас барсан

Нийт: 6,051,079

О-5 НАСНЫ ХҮҮХДҮҮД ҮГ ХАЛДВАРЫАР ӨВЧСӨН ТӨХИӨЛДӨЛД МАШ ХҮРДАН ХИЦЭРЭДЭЙ ТУЛ ЦАГ АЛДАЛГУЙ ЭМНЭЛЭГТ ХАНДААРНИ

Цахим шууданд

ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ч.ДАНЗАН АГСНЫ ГАВЬЯАТ ҮЙЛСИЙГ МӨНХЖҮҮЛЭХ ДУРСАМЖ УУЛЗАЛТ БОЛОВ



Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг угтан “Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл”-ээс Цэргийн улс төрийн ажилтан, хошууч генерал Чимидийн Данзангийн мэндэлсний 106 жилийн ойд зориулсан дурсамж уулзалт өчигдөр Монгол цэргийн музейд боллоо.

Дайны хоёр фронтод амь хайргүй тулалдаж, энх цагийн бүтээн байгуулалтад оройлон оролцсон домог түүхт генералын ойг өнгөрсөн жил тэмдэглэхээр төлөвлөсөн ч дэлхий нийтийг хамарсан цар тахлаас болж хойшлогдсоор өдий хүржээ.

Тус дурсамж уулзалтад Армийн Улс төрийн газрын орлогч дарга, БЦУГ-ын Улс төрийн хэлтсийн дарга асан Д.Пүрэвжав, Улс төрийн газрын Соёл урлагийн хэлтсийн дарга асан Д.Болд, Ц.Энхбаатар, Улс төрийн газрын намын байгууллагын хэлтсийн орлогч дарга асан Ш.Нанзад, Барилгын цэргийн ХЗЭ-ийн ахмад ажилтан, бэлтгэл хурандаа С.Жигжид, штабын ахмад ажилтан,

чөлөөнд байгаа дэд хурандаа Л.Ганбаатар, бэлтгэл хошууч П.Сүхбаатар болон барилгын цэргийн ангиудын байлдааны туган дор жагсаж явсан ахмадууд урилгаар оролцов.

Хошууч генерал Я.Данзан агсан нь 1939, 1945 оны дайны үед 6 дугаар морьт удирдагч, 15 дугаар морьт хорооны улс төрийн орлогчийн албан тушаалтайгаар хоёр удаагийн дайны фронтын тэргүүн шугамд явж гарамгай гавьяа байгуулсан эрхэм юм. Энэ эрхэм хүмүүний талаар тус уулзалтад оролцогсод

болох ахмад ажилтан, бэлтгэл хурандаа Г.Буянхишиг “Жингийн туухай дээр тавихад жин дарахаар эх орондоо байгуулсан гавьяатай, булавч бултайхаар бүтээлтэй генерал байсан” гэж яриу. БЦУГ-ын боловсон хүчний хэлтсийн дарга асан, чөлөөнд байгаа дэд хурандаа Д.Рагчаа “Барилгын цэрэг улс орныхоо бүтээн байгуулалтанд Д.Бавуу, Ч.Данзан гэсэн хоёр мундаг генералыг тугаа болгож явсан”, бэлтгэл хурандаа О.Бямбаа “Олон улсын Найрамдал зуслангийн бүтээн босгоход Данзан генералын оруулсан хувь нэмрийг үнэлж, нэрийг нь гол байрны хананд мөнхжүүлсэн” хэмээн дурслаа.

Мөн энэ үеэр “Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны Нэгдсэн эвлэл”-ын тэргүүн, бэлтгэл хурандаа Б.Жуваа Сүхбаатар аймаг дахь Барилга инженерийн 338 дугаар ангийг хошууч генерал Ч.Данзангийн нэрэмжит болгох саналыг БХЯ, ЗХЖШ, Барилга-инженерийн удирдах газар тавиад байгаа талаар дурдлаа.



“ХОЛИМОГ ГАР БӨМБӨГ”-ИЙН ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 234 дүгээр анги

Монгол Улс энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ой, алба, салбар сурталчлах аяны хүрээнд үйл ажиллагаагаа сурталчлах, хамт олны гар нийлэмж, нөхөрсөг харилцааг бэхжүүлэх, Хялганат тосгоны ард иргэд, бие бүрэлдэхүүний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг дэмжих, олон нийтийг хамарсан арга хэмжээнд татан оролцуулах багаар ажиллах чадварыг дээшлүүлэх зорилготой Хялганат тосгоны албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд “Холимог гар бөмбөг”-ийн тэмцээн зохион байгууллаа.

Уг тэмцээний үед цэргийн гэрээт албыг сурталчлах, тосгоны ард иргэдэд мэдээлэл хийж,



урлагийн тоглолт, жагсаалын болон гардан тулааны үзүүлэх тоглолт үзүүлж, ангийн үйл ажиллагааг харуулсан бичлэг, цэргийн гэрээт алба хаагчдыг сурталчилсан бичлэг шторкийг тус тус үзүүлж сонирхуулан иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэн ажилласан юм.

Холимог гар бөмбөгийн тэмцээнд нэгдүгээр байрыг Т.Эрдэнэ-Од ахлагчтай “Хялганат Оргил” ХХК-ны баг тамирчид, хоёрдугаар байрыг ахлах ахлагч Ц.Ундрах ахлагчтай “Байлдааны хангалт”-ын салбарын баг тамирчид, гуравдугаар байрыг ахлагч Г.Пүрэвням ахлагчтай “Хөвүүр гүүрийн рот”-ын I баг тамирчид тус тус эзэлж, өргөмжлөл, мөнгөн шагналын эзэд боллоо.

Түүнчлэн ангийн нийт эрэгтэй алба хаагчдын дунд



“Шагай харваа” тэмцээн, эмэгтэй алба хаагчдын дунд “Хөгжөөнт буухиа” тэмцээн тус тус зохион байгуулсан бөгөөд нийт 8 баг оролцсоноос нэгдүгээр байранд ахлагч Л.Манлайбаяр ахлагчтай “Инженер болон авто тээвэр засварын салаа”-ны баг тамирчид, хоёрдугаар байранд ахлагч М.Баасанжав ахлагчтай “Десант гатлалтын рот болон зам гүүрийн салаа”-ны баг тамирчид тус тус шалгарсан юм. Мөн “Хөгжөөнт буухиа” тэмцээнд нийт 4 баг өрсөлдсөнөөс нэгдүгээр байранд У.Мөнхбаяр ахлагчтай “Эвсэг” баг, хоёрдугаар байранд Г.Мөнхнаран ахлагчтай “3 бамбарууш” баг тус тус шалгарч бусдыгаа хошуучиллаа.

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ



“АХА” ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн I улирлын төгсгөлийн шалгалтыг угтаж “Зөрчлийн тухай хууль”-ийг хэн

сайн мэдэх вэ? сэдэвт танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг ангийн офицер, ахлагч, ажилтан алба хаагчдын дунд зохион байгуулав.

Хууль эрх зүйн чиглэлээр 115 асуумжийг /Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Монгол улсын цэргийн нийтлэг дүрмүүд, Зөрчлийн тухай хууль/ боловсруулж захиргаа удирдлагын албаны, хуулийн офицер, энгийн Б.Цэцэгээ удирдан зохион байгуулж явууллаа.

Хууль эрх зүйн мэдлэг, чадвараараа бусдыгаа манлайлан идэвх, санаачилгатай оролцож тэргүүн байрыг холбооны албаны шугам сүлжээний техникч дэд ахлагч Б.Мөнх-Эрдэнэ, дэд байрыг зэвсэг, галт хэрэгслийн нярав, ахлагч Ж.Бат-Эрдэнэ, гутгаар байрыг нууцын хэрэг хөтлөгч, дэд ахлагч Б.Батзориг нар тус тус эзэллээ.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАХ АЖЛЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 065 дугаар анги

“Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах” ажлын хүрээнд тус байгууламжийн галт хэрэглэлийн инженер, хадгалах тасгийн дарга ахмад Н.Энхтайванаар ахлуулсан 9 цэргийн алба хаагчтай бүлэг томилогдон энэ сарын 2-7-ний өдрүүдэд Дундговь аймгийн ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, Мандал сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд сурталчилгааны ажлыг амжилттай зохион байгууллаа.

Монгол Улсын Зэвсэгт хүчин, Агаарын цэргийн командлал Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн тусгай байгууламжийн танилцуулга хийж, “Цэрэг эх оронч хүмүүжил”, “Монгол цэрэг



дэлхийн цэрэг” сэдвээр сурагчдад харилцан ярилцлаа. Мөн тус сургалтаар ПМ гар буу, автоматын задаргаа угсаргаа, сумалгаа, хими хамгаалах хэрэгслийн иж бүрдэл, нормативыг тайлбарлан таниулсан юм.

Цаашид “Монгол өдөр”-ийг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд “Цэрэгжлийн норматив”-ийн тэмцээн зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



ЗАРЛАА

Монгол улсад өрчин цагийг, Зэвсэгт хүчний үүсгэлтэй байгуулагдсаны 101 жилийн ойд зориулсан “Алдар спорт хороо”-ны аварга шалгаруулах Улс Аймагийн алдар цолтой хүрээт бөхийн барилдааны болно. мөр: Зэвсэгт хүчний анги салбарт харьяалагддаг болон Алдар спорт хорооны тамирчид оршино.

Хугацаа: 2022 оны 3 сарын 14 ны 09:00 цагт
Хаана: “Алдар спорт хороо”
Утас-99190008, 88883540